



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 1 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Монголд Зочлох жил болгон зарласантай
холбогдуулан “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин”
бүрдүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн, Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4, 6.1.9, 6.2.10 дахь зорилтуудын хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор “2023-2025 оныг Монголд Зочлох жил” болгон зарласантай холбогдуулан орчны бохирдлыг бууруулах, эрүүл, аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэх зорилгоор Аймгуудын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

Нэг.Тухайн аймаг орон нутгийн хэмжээнд хог хаягдлын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:

1.Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан шар усны үерээс хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн цэвэрлэгээг сар тутам зохион байгуулах;

2.Орон нутагт эвент арга хэмжээ зохион байгуулахдаа талбайгаас 500 м–ээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлын цэг, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулж тэмдэгжүүлсэн байх;

3.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үүсгэгч нь хариуцах, санхүүжилт, урамшууллын шинэ системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;

4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах.

5.Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих, нутаг дэвсгэрийн хэмжээнд хадгалагдаж байгаа аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

6.Аймаг, сумын хог хаягдлын цэгийг хумих, цэгцлэх, булшлах арга хэмжээ авах;

152320014

Хоёр:Ариун цэврийн байгууламжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:

1.Хөрсний нян, бактер, хүнд металлын бохирдлын түвшинг тогтоох судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах;

2.Олон улсын, улсын болон орон нутгийн чанартай автозамын дагуух үйлчилгээний цэгүүдийн нүхэн жорлонг ашиглалтаас гарган буулгаж, хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээ авч, Нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламжтай болгох;

3.Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, Гэр хорооллын нүхэн жорлонд тавигдах Техникийн шаардлага MNS 5924:2019 шаардлага хангуулж, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж эко жорлонтой болгох арга хэмжээ авах;

4.Аймаг, сумын төвд MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламжийн тоог нэмж байгуулах;

5.Аймаг, сумын үйлчилгээний бүх байгууллагуудын ариун цэврийн өрөөг үнэгүй, нээлттэй болгож, иргэд, жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх;

6.Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй худалдаа үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг MNS 4943:2011 стандартын шаардлага хангуулах;

7.Аялал жуулчлалын баазуудын нүхэн жорлонг буулгаж MNS 5924:2019 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох;

8.Автозасвар, тос тосолгооны төв, автомашины угаалгын газар, хүнсний болон барааны зах, худалдааны төв, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуй ариун цэврийн шаардлагуудыг хангуулах, ариун цэврийн байгууламжуудыг стандартад нийцүүлэх, холбогдох хууль тогтоож, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт зохион байгуулах;

9.Автозасварын төвүүдийг саарал ус ашиглах технологи санаачилгыг сум, орон нутгийн хэмжээнд дэмжих;

Гурав:Тухайн аймаг орон нутгийн хэмжээнд ил задгай хог хаягдлын цэвэрлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

1.Аймаг, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын гадна орчны их цэвэрлэгээг тогтмол хийх ажил өрнүүлж, эрүүл аюулгүй, цэвэр орчин бий болгох;

2.Зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг, зэмийг мал эмнэлгийн байгууллагын хяналтан доор халдваргүйтгэх болон устгах, булшлах үйл ажиллагааг зохион байгуулж, аливаа өвчин эмгэг тархах болон байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.Аялал жуулчлалын бүс нутаг дахь уул овооны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх;

4.Тохижилт үйлчилгээний компаниудын ажлыг эрчимжүүлж зам дагуух хашлага хайс болон бусад нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулах;

Дөрөв.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулан, сар бүрийн 25-ны дотор тухайн сард авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг, нэгдсэн биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Тав.Тус албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосугай.

САЙД  Б.БАТ-ЭРДЭНЭ